

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ	ХАРИУЦСАН АЛБАН ХААГЧ
I.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр						
1.	Байгууллагын албан хаагчдын дунд ёс зүйн асуудлын хүрээнд санал хүсэлт, судалгаа авах.	Ёс зүйн үнэлгээний түвшин	Албан хаагчдын дунд ёс зүйн түвшинг үнэлнэ.	Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар тогтоосон төрийн албан хаагчдын баримтлах ёс зүйн зарчим, хэм хэмжээг байгууллагын хүрээнд судлах судалгааг Google form платформоор боловсруулан онлайн хэлбэрээр 2024 оны 4 дүгээр сарын 03-27-ны өдрүүдэд зохион байгуулж судалгаанд ЗДТГ, хороодын 68 албан хаагч хамрагдсан.	100%	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг
2.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн мэдлэг олгох болон ёс зүйн бусад чиглэлийн сургалтад албан хаагчдыг хамруулах.	Мэдлэгийн түвшин	Төрийн албан хаагчид ёс зүйн зарчим, хэм хэмжээний талаар мэдлэгтэй болно.	- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн дагаж мөрдөх ёс зүйн хэм, хэмжээ”, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ыг албан хаагчдад таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооноос 2024 оны I улирлын үйл ажиллагааны тайлан, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл танилцуулах 5 удаагийн арга хэмжээнд 04 дүгээр сарын 03-11-ний өдрүүдэд Засаг даргын Тамгын газрын 56, хорооны 49, нийт 105 албан хаагчдыг хамруулсан. - Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хорооны 7-4-10 зорилтот сургалтын хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр цахимаар зохион байгуулсан “Дижитал ёс зүй”	100%	Ёс зүйн дэд хорооны гишүүд

				сэдэвт сургалтад 25 хорооны 138 хэсгийн ахлагчдыг хамруулж цахим орчинд ёс зүйтэй харилцах мэдлэг олгосон.		
3.	Ёс зүйн аяны хүрээнд уралдаант, чөлөөт арга хэмжээ зохион байгуулах.	Арга хэмжээ, албан хаагчдын тоо	Албан хаагчдыг 4-өөс доошгүй арга хэмжээнд хамруулж, ёс зүйн төлөвшил, хандлага сайжирна.	<ul style="list-style-type: none"> - Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг төрийн албан хаагчдад таниулах, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Morning QUIZ арга хэмжээг зохион байгуулж ЗДТГ-ын 70 албан хаагчийг хамруулсан. QUIZ асуултад дээрх хуулиуд болон хөгжөөнт, танин мэдэхүйн асуултуудаас бүрдсэн бөгөөд эхний 3 байр тус бүр 1 албан хаагч шалгаруулж, мөнгөн шагнал олгосон. - Засаг даргын Тамгын газар болон хорооны төрийн албан хаагчдын өдөр тутмын ажлын хэрэгцээнд зориулж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн холбогдох заалт бүхий 400 ширхэг дэвтэр хэвлүүлж, нийт албан хаагчид олгон өдөр тутмын ажлын хэрэгцээнд ашиглаж байна. - Төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, оролцоо идэвхийг сайжруулах зорилтын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хорооны гишүүн М.Цэрэнбаттай хамтран “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт илтгэлийг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулж, Засаг даргын Тамгын газрын 39, хорооны 46, нийт 85 албан хаагч хамрагдсан. - Хан-Уул дүүргийн иргэдэд үйлчлэх төв байранд байрладаг төрийн байгууллагуудын албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйн мэдлэгийг дэмжих зорилгоор Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдад Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль болон холбогдох баримт бичгийг таниулах, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, ажиллах журмыг танилцуулах уулзалт арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулж, уулзалтад тус албаны 14 албан хаагч хамрагдсан. Хэрэгжилт 100% 	100%	Ёс зүйн дэд хорооны гишүүд

4.	Төрийн албан хаагчдын ёс зүйн асуудлаар иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	Сэтгэл ханамжийн хувь	Хэрэглэгчийн үнэлгээнд үндэслэн албан хаагчдын ёс зүйн түвшинг үнэлнэ.	Хан-Уул дүүргийн Иргэдэд үйлчлэх төв байрны Нэг цэгийн үйлчилгээний төв болон хороодоор үйлчлүүлсэн 200 иргэнээс төрийн албан хаагчийн үйлчилгээ үзүүлж буй байдлыг дүгнэх сэтгэл ханамжийн судалгааг 2024 оны 12 дугаар сарын 02-25-ны өдрүүдэд авч, судалгааны үр дүнг нэгтгэн 2025 онд хэрэгжүүлэх авлигын эсрэг төлөвлөгөө, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгахаар боловсруулсан.	100%	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг
5.	Иргэд, албан хаагчдын судалгааны дүнд үндэслэн ЗДТГ-ын хэлтэс, хороодод ёс зүйн асуудлаар зөвлөмж хүргүүлэх	Зөвлөмж хүргүүлсэн эсэх	ЗДТГ-ын хэлтэс, хороодод төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх санал, зөвлөмж хүргүүлсэн байна.	Иргэд, албан хаагчдын судалгааны дүнд үндэслэн ЗДТГ-ын хэлтэс, хороодод ёс зүйн асуудлаар зөвлөмж хүргүүлэхээр боловсруулсан.	50%	Ёс зүйн дэд хорооны гишүүд
6.	Соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээний хүрээнд зураг, дүрс бичлэг, цахим хэлбэрээр танилцуулга, мэдээлэл бэлтгэж, иргэд, төрийн албан хаагчдад хүргэх.	Мэдээ, мэдээллийн тоо	2-оос доошгүй мэдээллийг албан хаагч, иргэдэд хүргэж, төрийн албан хаагчдын ёс зүйн төлөвшил, хандлага сайжирна.	Албан хаагчдын гаргасан ёс зүйн болон сахилгын зөрчлийн шалтгаан нөхцөлд үндэслэн Төрийн албан хаагчид ажлын цагаар, ажлын байран дээрх хувцаслалтандаа Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8.1.2, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын "Захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын дагаж мөрдөх харилцаа, хандлагын нийтлэг журам"-ын 3.2-т заасан шаардлагыг мөрдөх анхааруулга, зурагт хуудсыг Засаг даргын Тамгын газар, хороодын албан хаагчдын цахим бүлгэмд 4 дүгээр сарын 22, 6 дугаар сарын 17-ны өдөр тус тус байршуулж, албан хаагчдыг 2 удаагийн зөвлөгөө, мэдээллээр хангасан. Хэрэгжилт 100%	100%	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг
II.Зөрчил хянан шийдвэрлэх						
7.	Иргэд, байгууллагаас төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийж, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоох	Шалтгаан нөхцлийг тогтоосон байдал	Ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцлийн дагуу арга хэмжээ авах нөхцөл бүрдэнэ.	Төрийн албан хаагчийн ёс зүй зөрчил 3, сахилгын зөрчил 1 тогтоогдсоноос: - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн •8 дугаар зүйлийн 8.1.1,-т заасан Иргэний хүсэлтэд анхааралтай хандаж, хууль заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх шаардлагыг зөрчсөн зөрчил 1, •8 дугаар зүйлийн 8.1.2-т заасан Эрх бүхий байгууллагаас баталсан хувцаслалтын шаардлагыг зөрчсөн зөрчил 1, •8 дугаар зүйлийн 8.2.1-т заасан Төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг үг, үйлдлээр эсэргүүцэх, бусдыг өдөөн турхирах зөрчил 1,	100%	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг

				Хөдөлмөрийн тухай хуулийн 123.1, Хөдөлмөрийн дотоод журмын 13.3.1-т заасан ажлын цаг ашиглалтын зөрчил 1 тус тус тогтоогдсон.		
8.	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэж, дүгнэлтийг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх.	Шийдвэрлэсэн гомдлын тоо	Ёс зүйн зөрчилд дүгнэлт хийж, хариуцлага тооцно.	Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар иргэдээс ирүүлсэн 12 албан хаагчид холбогдох гомдол, мэдээллийг 6 удаагийн хурлаар хэлэлцэн, ёс зүйн зөрчил тогтоогдсон 3 албан хаагчид Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.2 дахь заалтад заасан ёс зүйн хариуцлага хүлээлгэж, 5 албан хаагчид ёс зүйн дэд хорооны зөвлөмжийг хүргүүлсэн.	100%	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг
III. Ёс зүйн дэд хорооны хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр						
9.	Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлуулах.	Төсөв батлуулсан эсэх	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байна.	Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний төсвийг тухай бүр боловсруулан Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, нийт 2 удаагийн арга хэмжээнд төгрөгийн батлагдсан төсвийг зарцуулсан.	100%	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг
10.	Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт, арга хэмжээнд хамруулах.	Хамрагдсан байдал	1-ээс доошгүй арга хэмжээнд хамрагдаж зөрчил хянан шийдвэрлэх чадамж дээшилнэ.	Удирдлагын академи, НЗДТГ хамтран зохион байгуулсан “Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах” сургалтад Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг 2024 оны 3 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд хамрагдаж ёс зүйн зөрчил шийдвэрлэлт, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох мэдлэг, арга зүйг эзэмшсэн.	100%	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг
11.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.1 дэх заалтын хүрээнд гишүүдэд урамшуулал олгох саналыг ЗДТГ-т хүргүүлэх.	Санал боловсруулсан эсэх	Холбогдох журамд тусгуулж, батлуулна.	Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын дагуу дэд хорооны гишүүдэд улирал тутам, нарийн бичгийн даргад сар тутам урамшууллыг олгуулахад шаардлагатай тайлан, мэдээг тухай бүр Санхүүгийн тасагт хүргүүлсэн.	100%	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг
12.	Ёс зүйн дэд хорооны ажиллах журам шинэчлэн батлуулах.	Журам шинэчилсэн байдал	Үйл ажиллагаа тасралтгүй, хэвийн явагдах нөхцөл бүрдэнэ.	Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн дэд хорооны журам”-д тусгах саналыг боловсруулан Засаг даргын Тамгын газрын 2024 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 03/382 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд хүргүүлсэн.	100%	Ёс зүйн дэд хорооны гишүүд

IV. Үйл ажиллагааг тайлагнах, мэдээлэх

13.	Ёс зүйн дэд хорооны 2024 оны хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайланг холбогдох дээд байгууллагад хүргүүлэх.	Тайлан хүргүүлсэн тоо	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайланг 2-оос доошгүй удаа хүргүүлнэ.	Ёс зүйн дэд хорооны 2024 оны хагас жилийн тайланг батлагдсан загварын дагуу боловсруулж, дэлгэрэнгүй мэдээллийн хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2 удаа хүргүүлсэн.	100%	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг
14.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлт, ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулж, олон нийтэд мэдээлэх.	Мэдээлсэн эсэх	2024 оны I хагас, жилийн эцэст мэдээллийг цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийг ил тод мэдээллээр хангана.	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг улирал тутам шинэчлэн www.khanuul.mn цахим хуудаст байршуулж ил тод мэдээлсэн.	100%	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг

Төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлт 14 арга хэмжээ 96 хувьтай.